Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг тэсэлгээ, хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн			X	
Элс хайрга олборлох үед болон уурхайгаас гарах грунтын уснаас хамгаалах, хорт бодис, нэгдлээс хамгаалах асуудал хир нийцтэй тусгагдсан, үр ашигтай ажиллах явдал хир зэрэг зохимжтой	X			
Гидравлик даралттай усны цоргоор гарах булингартай усыг тунгаах, урсгал усны чанарыг хамгаалах, хянах асуудал	X			
Эрдсийг боловсруулах технологийн үйл ажиллагааны үед ус, агаар, хөрс, бохирдох, хатуу хог хаягдал болон их дуу чимээ гарах			X	
Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх				X
Уурхайн үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төрөлд тусгагдсан эсэх			X	
3. Барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаатай холбогдож гарах байгаль орчны асуудал				
Барилга байгууламж барих үед усны нөөц бохирдох байдал	x			

Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт орших “Дархан толгой” нэртэй барилгын
чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн 2024 оны БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Барилга байгууламж барих үеийн болон барьсны дараах хөрсний элэгдэл эвдрэл			X	
Үйлдвэрлэлийн осол аваарь, хортой нөхцөл үүсэх, халдварт өвчин гарах нөхцөл		x		
4. Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх				X
Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх			X	
Хөрсний эвдрэл элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа)				X
Эрдэс баялгийг авч ашиглах зэргээс шалтгаалж хөрсөнд ус нэвчих, гүний ус бохирдох, улмаар хөрсний усны горимд эсрэгээр нөлөөлөх	X			
Газар ашиглалтанд хохирол учруулах, үйл ажиллагаа явуулах үед газар тэгшлэх, буцааж булаах ажлыг хамгийн бага байлгах нь бусад зорилгод ашигтай байж болох, хөрш зэргэлдээх газар ашиглалтанд гэмтэл учруулахгүй байх зэрэг асуудал төсөлд тусгагдсан эсэх			X	
Шуурхай хяналтын асуудал (төсөлд шуурхай хяналтын хугацаа, мөнгө зардал тусгагдсан эсэх)		X		
Уурхайд элс хайрга олборлохоос гадна бусад эрдэс олборлох ашиглах боломжийг авч үзсэн эсэх	X			
Төслийг хэрэгжүүлэх үеийн инженерийн болон санхүүгийн боломжийн талаарх асуудал				x
5. Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)				
Төслийг хэрэгжүүлэх явцад байгалийн бусад нөөц баялагийг ашиглах боломжийг ашиглахгүй орхигдуулахгүй	X			
Төслийн техник технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд олон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх асуудал		x		

Төсөл хэрэгжих байршлын хувьд хүн амыг нүүлгэн шилжүүлэх, түүх соёлын археологийн олдворт газарт ямар нэгэн нөлөөлөл байхгүй.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал, мөн үйл ажиллагаанаас гарах дуу чимээг багасгах талаар дунд зэргийн үр дагавартай байна.

Дээр өгүүлсэн болзошгүй нөлөөллийн судалгааны үр дүнгээс төсөл хэрэгжих үеийн болон ашиглалтын үе шатанд хөрс, агаар, бэлчээр, газрын доорх ус зэрэгт ихээхэн нөлөөтэй болох нь харагдаж байна. Иймд эдгээр нь голлох нөлөөлөлд багтана. Сөрөг нөлөөллийг байгаль орчны үзүүлэлт тус бүрээр дэлгэрэнгүй авч үзлээ.

1. Газрын гадарга

Уг төсөл хэрэгжих талбай нь геоморфологийн мужлалаар Орхон Сэлэнгийн мужид хамаарна. Ус хагалбарын хувьд Умард мөсөн далайн ай савд хамрагдана.

2. Цаг уур

Төсөл хэрэгжих орчны бүс нутаг нь эх газрын эрс тэс хахир ширүүн уур амьсгалтай. Уур амьсгалын үзүүлэлтийн шинж нь тэгш хэмийн 4 улирлын хуваарилалттай. Чийглэгдүү сэрүүн, нэн хүйтэн уур амьсгалын ангилалд хамрагдана.

Уг төсөл нь Монгол орны уур амьсгалын эрс тэс нөлөөллийн дор хэрэгжих тул үйл ажиллагааны үед цаг агаар, уур амьсгалын нөхцөл ихээхэн нөлөөтэй байх болно.

Төсөл хэрэгжих явцад тоосжилт үүсэх зэргээр бохирдуулагч бодисын тоо хэмжээ нэмэгдэх ч стандарт хэмжээнээс давж, бохирдуулах хэмжээнд хүрч үйлчлэхгүй тул орон нутгийн уур амьсгалыг өөрчлөгч хүчин зүйл болж чадахгүй.

3. Агаарын чанар

Уурхай орчмын нутаг дэвсгэрийн хөрс эвдэгдэж тоосрох, хүнд даацын автомашины хөдөлгөөн, автомашин механизмын яндангаас гарах хорт хийн хаягдал нь агаар дахь бохирдуулах бодисын агууламжийг ихэсгэнэ.

Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, уг ажилд ашиглагдах тоног төхөөрөмж, машин механизм, тээврийн хэрэгслээс гарах утаа зэрэг эх үүсвэрүүдээс тоосжилт, агаарын бохирдол үүснэ.

4. Хөрсөн бүрхэвч

Төсөл хэрэгжих талбай нь Хөрс-газарзүйн мужлалтаар Төв Азийн бүсийн Хангайн их мужийн өргөргийн бүсшилийн хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүсийн 4-р тойргийн нутагт хамрагдана. Тухайн нутагт хөрс үүсгэгч эх чулуулаг нь гол төлөв механик бүрэлдэхүүний болон сайр чулууны агууламж, карбонатын хэмжээгээр жигд биш делюви, пролювийн болон элювийн гаралтай сэвсгэр хурдсаас голлон тогтсон байна. Дээрх өргөргийн бүсэд хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүсийн 4-р тойрогт уулын хар шороон, хар хүрэн, цайвар хүрэн, нугат хүрэн хөрс голлон тархана. Үйлдвэр орчимд цайвар хүрэн хөрс тархсан байна.

Уурхай орчмын хөрс нь авто машины болон хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртөнө. Хуурай хог хаягдлаар орчин бохирдох, хөрсний бохирдол үүсэх зэргээр нөлөөлнө. Тээвэрлэлтээс хөрсний бүтэц эвдрэх, газрын гадарга, хөрс ахуйн хаягдал шатахуун, бохирдож болзошгүй.

5. Ургамлан нөмрөг

Үүний улмаас орчны ургамлын өнгө зүс алдагдаж, навчны амсар хаагдаж ургамлын навчны хэмжээ жижгэрэх, навч нь эрт унах, фотосинтезийн идэвх буурах, өсөлт нь удаашрах, ургамал бүхэлдээ давжаарах улмаар бүр мөсөн ургахаа болих зэрэг байдал бий болж болзошгүй. Ургамлын навчинд бууж тогтсон нарийн ширхэгтэй шороон хучлага ургамлын амьдрах чадварт сөргөөр нөлөөлнө.

Дээр өгүүлсэн болзошгүй нөлөөллийн судалгааны үр дүнгээс төсөл хэрэгжих үеийн болон ашиглалтын үе шатанд хөрс, агаар, бэлчээр, газрын доорх ус зэрэгт ихээхэн нөлөөтэй болох нь харагдаж байна. Иймд эдгээр нь голлох нөлөөлөлд багтана. Сөрөг нөлөөллийг байгаль орчны үзүүлэлт тус бүрээр дэлгэрэнгүй авч үзлээ.

6. Газрын гадарга

Уг төсөл хэрэгжих талбай нь геоморфологийн мужлалаар Орхон Сэлэнгийн мужид хамаарна. Ус хагалбарын хувьд Умард мөсөн далайн ай савд хамрагдана.

7. Цаг уур

Төсөл хэрэгжих орчны бүс нутаг нь эх газрын эрс тэс хахир ширүүн уур амьсгалтай. Уур амьсгалын үзүүлэлтийн шинж нь тэгш хэмийн 4 улирлын хуваарилалттай. Чийглэгдүү сэрүүн, нэн хүйтэн уур амьсгалын ангилалд хамрагдана.

Уг төсөл нь Монгол орны уур амьсгалын эрс тэс нөлөөллийн дор хэрэгжих тул үйл ажиллагааны үед цаг агаар, уур амьсгалын нөхцөл ихээхэн нөлөөтэй байх болно.

Төсөл хэрэгжих явцад тоосжилт үүсэх зэргээр бохирдуулагч бодисын тоо хэмжээ нэмэгдэх ч стандарт хэмжээнээс давж, бохирдуулах хэмжээнд хүрч үйлчлэхгүй тул орон нутгийн уур амьсгалыг өөрчлөгч хүчин зүйл болж чадахгүй.

8. Агаарын чанар

Уурхай орчмын нутаг дэвсгэрийн хөрс эвдэгдэж тоосрох, хүнд даацын автомашины хөдөлгөөн, автомашин механизмын яндангаас гарах хорт хийн хаягдал нь агаар дахь бохирдуулах бодисын агууламжийг ихэсгэнэ.

Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, уг ажилд ашиглагдах тоног төхөөрөмж, машин механизм, тээврийн хэрэгслээс гарах утаа зэрэг эх үүсвэрүүдээс тоосжилт, агаарын бохирдол үүснэ.

9. Хөрсөн бүрхэвч

Төсөл хэрэгжих талбай нь Хөрс-газарзүйн мужлалтаар Төв Азийн бүсийн Хангайн их мужийн өргөргийн бүсшилийн хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүсийн 4-р тойргийн нутагт хамрагдана. Тухайн нутагт хөрс үүсгэгч эх чулуулаг нь гол төлөв механик бүрэлдэхүүний болон сайр чулууны агууламж, карбонатын хэмжээгээр жигд биш делюви, пролювийн болон элювийн гаралтай сэвсгэр хурдсаас голлон тогтсон байна. Дээрх өргөргийн бүсэд хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүсийн 4-р тойрогт уулын хар шороон, хар хүрэн, цайвар хүрэн, нугат хүрэн хөрс голлон тархана. Үйлдвэр орчимд цайвар хүрэн хөрс тархсан байна.

Уурхай орчмын хөрс нь авто машины болон хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртөнө. Хуурай хог хаягдлаар орчин бохирдох, хөрсний бохирдол үүсэх зэргээр нөлөөлнө. Тээвэрлэлтээс хөрсний бүтэц эвдрэх, газрын гадарга, хөрс ахуйн хаягдал шатахуун, бохирдож болзошгүй.

10. Ургамлан нөмрөг

Үүний улмаас орчны ургамлын өнгө зүс алдагдаж, навчны амсар хаагдаж ургамлын навчны хэмжээ жижгэрэх, навч нь эрт унах, фотосинтезийн идэвх буурах, өсөлт нь удааширах, ургамал бүхэлдээ давжаарах улмаар бүр мөсөн ургахаа болих зэрэг байдал бий болж болзошгүй. Ургамлын навчинд бууж тогтсон нарийн ширхэгтэй шороон хучлага ургамлын амьдрах чадварт сөргөөр нөлөөлнө.

Дээр өгүүлсэн болзошгүй нөлөөллийн судалгааны үр дүнгээс төсөл хэрэгжих үеийн болон ашиглалтын үе шатанд хөрс, агаар, бэлчээр, газрын доорх ус зэрэгт ихээхэн нөлөөтэй болох нь харагдаж байна. Иймд эдгээр нь голлох нөлөөлөлд багтана. Сөрөг нөлөөллийг байгаль орчны үзүүлэлт тус бүрээр дэлгэрэнгүй авч үзлээ.

3.2.3. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл

Төслийн хүрээнд барилгын чулуу олборлолт явагдана. Иймд уурхайн байгаль орчны сөрөг нөлөөллийн асуудлыг авч үзэхдээ Леопольдын матрицын аргыг хэрэглэв. Энэ нөлөөллийн чухал байдлын зэрэглэл ба нөлөөллийн болзошгүй утгыг 1-10 хүртэл оноогоор нилээд дэлгэрэнгүй байдлаар тодорхойлов. Ийнхүү үнэлгээ өгөхдөө аль болохоор бодит байдалд тулгуурласан нарийн мэргэжлийн шинжээчдийн дүгнэлтийг үндэс болголоо. Леопольдын матрицын арга нь дараах 3 үйлдэл хийхийг шаарддаг. Үүнд:

- ✓ Хэрэв экологийн тогтолцоонд төслийн технологийн үе шатны аль нэг үйл ажиллагаа нь нөлөөлөхөөр байвал түүнд харгалзах дөрвөлжинг ташуу зураасаар 2 хуваана.
- ✓ Хуваагдсан хэсгийн доод талд болзошгүй нөлөөллийн чухал байдлыг 1-10 хүртлэх тоогоор үнэлнэ.
- ✓ Хуваагдсан хэсгийн дээд талд мөн 1-10 хүртлэх оноогоор болзошгүй нөлөөллийн хүчтэй эсэхийг үнэлэн бичнэ. Үүнд: 1 балл бол үнэлгээний хамгийн бага, 10 нь хамгийн их утга юм.

Хүснэгт 7. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл

Технологийн үе шат Байгаль орчны үзүүлэлт	Хөрс хуулах	Нүх карьер	Овоолго	Ачих	Тээвэрлэх
Агаар	7/10	5/6	6/6	6/7	5/5
Хөрс	9/10	8/9	7/7	4/5	4/5
Ургамал (бэлчээр)	9/10	10/10	3/4	2/2	6/7
Амьтан	3/5	2/2	2/2	1/1	1/1
Геологийн тогтоц	8/8	6/7	2/2	1/1	1/1

Дээр дурьдсанаас үзвэл технологийн үе шатууд нь янз бүрийн эрчимтэйгээр байгаль орчинд нөлөөлдөг байна. Үүнд:

Хөрс хуулах:

Барилгын чулууг ил уурхайн аргаар ашиглаж буй тул хөрс хуулалтын ажил явуулах үед их хэмжээний тоос агаарт гарах, мөн ойр орчмын хөрс, ургамлын бүрхүүлд нөлөөлж байна. Түүнчлэн хөрс хуулах ажил тухайн газар орны геологийн тогтоцыг шууд өөрчилж буй тул нөлөөлөлд өндөр оноо өгсөн байна.

Нүх, карьер, овоолго:

Уурхайн үйл ажиллагааны үед бий болсон нүх, карьер, овоолго нь салхитай үед тоосны байнгын эх үүсвэр болдог бөгөөд агаар болон ойр орчмын хөрс тоосоор бохирддог байна. Бохирдлын түвшний хувьд энэ нь хөрс хуулах, ачих үеийнхээс харьцангуй бага юм.

Ачих, тээвэрлэх:

Уурхайгаас олборлосон барилгын чулууг экскаватороор автосамосвалд ачих, үед мөн агаар, ойр орчмын хөрс бохирдох нөхцөл бүрддэг байна.

Ургамал, Хөрс хуулах:

Нийт талбайн ургамалан бүрхэвч нөмрөг бүхэлдээ усдаж үгүй болно.

Нүх, карьер:

Уурхайн үйл ажиллагааны үед бий болсон нүх, карьер, овоолго нь салхитай үед тоосны байнгын эх үүсвэр болдог бөгөөд үүний улмаас орчны ургамлын өнгө зүс алдагдаж, навчны амсар хаагдаж ургамлын навчны хэмжээ жижгэрэх, навч нь эрт унах, фотосинтезийн идэвх буурах, өсөлт нь удаашрах, ургамал бүхэлдээ давжаарах улмаар бүр мөсөн ургахаа болих зэрэг байдал бий болж болзошгүй.


Тээвэрлэх:

Уурхайгаас олборлосон барилгын чулууг ачиж тээвэрлэх үед тоосжилт үүсэж ургамлын навчинд бууж тогтсон нарийн ширхэгтэй шороон хучлага ургамлын амьдрах чадварт сөргөөр нөлөөлнө.

Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт орших “Дархан толгой” нэртэй барилгын чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн 2024 оны БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. Гол сөрөг нөлөөлөл

№	Байгаль орчны хүчин зүйлс	Гол сөрөг нөлөөлөл
1	Газрын гадарга, хөрс	Уурхай орчмын хөрс нь авто машины болон хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртөнө. Хуурай хог хаягдлаар орчин бохирдох, хөрсний бохирдол үүсэх зэргээр нөлөөлнө. Тээвэрлэлтээс хөрсний бүтэц эвдрэх, газрын гадарга, хөрс ахуйн хаягдал шатахуун, тослох материалаар бохирдож болзошгүй.
2	Ургамал	Нийт талбайн ургамалан бүрхэвч нөмрөг бүхэлдээ усдаж үгүй болно. Нөхөн сэргээгдэх байдал хязгаарлагдмал. Үүний улмаас орчны ургамлын өнгө зүс алдагдаж, навчны амсар хаагдаж ургамлын навчны хэмжээ жижгэрэх, навч нь эрт унах, фотосинтезийн идэвх буурах, өсөлт нь удаашрах, ургамал бүхэлдээ давжаарах улмаар бүр мөсөн ургахаа болих зэрэг байдал бий болж болзошгүй. Ургамлын навчинд бууж тогтсон нарийн ширхэгтэй шороон хучлага ургамлын амьдрах чадварт сөргөөр нөлөөлнө.
3	Агаар	Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, уг ажилд ашиглагдах тоног төхөөрөмж, машин механизм, тээврийн хэрэгслээс гарах утаа зэрэг эх үүсвэрүүдээс тоосжилт, агаарын бохирдол үүснэ.



Зураг 3. Төсөл хэрэгжих талбайн нөлөөллийн бүс

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг тогтмол хянах зорилготой. Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорино.

Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт хэрэгжих “Дархан толгой” нэртэй барилгын чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, Монгол улсын засгийн даргын тогтоол, 2023 оны 02 дүгээр сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам” –ын дагуу, тус төслийн 2022 оны байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан зэрэгт тулгуурлан боловсруулав.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Суурь” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 6.6 сая төгрөг төлөвлөв. Үүнд: Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардалд 0.4 сая.төг, осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын зардалд 1.5 сая.төг, дүйцүүлэн хамгаалах зардалд 1.0 сая.төг, хог хаягдал менежментийн төлөвлөгөөнд 0.3 сая.төг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт 0.4 сая.төг, тэрбум модны хүрээнд 1.5 сая.төг, байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэхэд 1.5 сая.төг, зарцуулахаар төлөвлөлөө.

4.1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал

Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар орчин				
Уурхай орчимд тоосжилт үүсэх	Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх	Жилд 2 удаа	ОХШХ-ийн зардлаас	MNS 4585:2007” “Гадаад орчны агаарын түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж болон зөвшөөрөгдөх түвшин стандарт MNS 5916:2008
Тоног төхөөрөмж, автомашины үйл ажиллагааны явцад агаар орчинд хорт хийн ялгарал үүснэ.	Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдэд оношлогоог тогтмол хийлгэж, тэдгээрт засвар үйлчилгээ хийж, түлшний зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх	Авто машины тээвэр хийх үед	400.0	MNS 4585:2007” “Гадаад орчны агаарын түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж болон зөвшөөрөгдөх түвшин стандарт MNS 5013:2003 Бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 Дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид
Хөрсөн бүрхэвч				
Уурхайн замын ачааллаас хөрс элэгдэж, эвдрэлд орох	Хүнд машин механизм явах замыг засаж сайжруулан, байгалийн хөрс бүхий замаар тээвэрлэлт аль болох бага хийх	Ашиглалтын явцад	-	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай Монгол улсын хууль MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
Хог хаягдлаар хөрс бохирдож болзошгүй	Хог хаягдлыг, тогтсон нэг цэгт төвлөрүүлж, ариутгах, зайлуулах арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хийх	Тухай бүрт	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардлаар	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай Монгол улсын хууль
Ургамлан нөмрөг				

Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт орших “Дархан толгой” нэртэй барилгын чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн 2024 оны
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Уурхайгаас барилгын чулуу олборлох, хөрс хуулах зэрэг ажлын үед ургамал устах, дарагдах, талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөнө.	Нөхөн сэргээлтэнд ашиглах хөрсний шимт хэсгийн овоолгыг стандартын дагуу тусгайлан овоолж, салхинд хийсэхээс хамгаалах.	Шимт хөрс хуулалтын үед, зам, карьер болон бусад газрын ашиглалт дууссаны дараа	Нөхөн сэргээлтийн зардлаар	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт. Хадгалалт MNS5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага 2 000 000
Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн БОАЖГ-аас заасан талбайд мод тарих	Дархан-Уул аймгийн БОАЖГ-тай хамтран сонгосон талбайд	Уурхайн зардлаар	
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардлын дүн			400.0	

4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө


Уурхайн олборлолт нь 2024 онд гүн рүү явагдах тул техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх талбай байхгүй.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны тоог уурхай болон үйлдвэр байршиж буй байгалийн бүсчлэлийг харгалзан MNS5918:2023, байгаль орчин, эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлагын дагуу 100 ширхэг модыг тарина.

Хүснэгт 10. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ажил

Мод тарих талбай, солбицолын цэг	Тарих модны тоо/ширхэг	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
49°30'2.56"N, 106°13'45.72"E 49°30'3.15"N, 106°13'52.15"E 49°29'51.49"N, 106°13'48.12"E 49°30'1.05"N, 106°13'42.21"E	100ш	0.25 га	1.5 сая.төг	2024

Зулзагын голын нарсан ойг тэлэх ойжуулалтын ажилд 100 ширхэг мод тарихаар төлөвлөллөө.



Зураг 4. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих газрын талбай

4.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 11. Эвдэрсэн газар техникийн нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Дархан сумын 6-р багийн Дархан толгой уулын урд	Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх	Дархан-Уул аймгийн БОАЖГ-тай хамтран сонгосон 0.1 га талбайд	1 сая.төгрөг	2024 онд

Дархан-Уул аймгийн БОАЖГ -аас санал болгосон төслийн талбайгаас 500м орчим зайд Дархан сумын 6-р багийн Дархан толгойн уулын урд дахь эвдэрсэн нийт 4.43 га газрын 0.1 га талбайд нөхөн сэргээлт хийнэ. Техникийн нөхөн сэргээлтийг өөрсдийн техник төхөөрөмжөөрөө хийж зардалыг дотоод үйл ажиллагааны зардлаас гаргана. 0.1 га талбайд биологийн нөхөн сэргээлтэнд 1 сая. Төгрөг зарцуулна.

Дүйцүүлэн хамгаалах газрын солбицол цэгүүд:

- 1) 49°30'33.19"N 105°57'51.3"E
- 2) 49°30'34.05N " 105°57'50.99"E
- 3) 49°30'34.26"N 105°57'52.56" E
- 4) 49°30'33.66"N 105°57'52.81"E
- 5) 49°30'32.88"N 105°57'52.25"E



Зураг 5. Дүйцүүлэн хамгаалах газрын Google Earth дээрх зураг

4.4. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 12. Осол, эрсдэл, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний зардал

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Зардал, мян.төг
Энэхүү тайлангийн сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх	--*--
Ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулж, хамруулах	500.0
Ажиллагсадыг улиралд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах.	500.0
Ажиллагсадыг тоосноос хамгаалах хошуувч, хувцас хэрэгслээр хангах	500.0
Нийт зардал	1500.0

4.5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хог хаягдлын цэг, ангилан ялгах үйлдвэрийн талбай, кемп орчимд бохирдол үүсгэж болзошгүй	Хог хаягдлыг ялгах, зайлуулах, устгах, цэвэршүүлэх менежментийн төлөвлөгөөг мөрдөн ажиллах	300.0	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
Нийт		300.0	

4.6. Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх хуваарь

Хүснэгт 14. Байгаль орчны аудит

Үзүүлэлт	Нэгжийн өртөг	Нийт өртөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, стандарт ба аргачлал
Байгаль орчны төлөвлөгөөнт аудит	1.5 сая.төг	1.5 сая.төг	2024	“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 10 ¹ дүгээр зүйл

4.7. Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 15. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал

Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Агаарын чанар				
SO ₂ , NO ₂ , CO, Тоос,	Уурхайн карьер, гол зам, тосгон орчим 3 цэгт	Жилд 1 удаа, намар	100.0	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Агаар бохирдуулагч бодисуудын ялгарлын хэмжээ	Ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүд	Жилд 1 удаа	Гүйцэтгэгч компанийн үйлдвэрлэлийн зардлаас	MNS 5013:2003 Бензин хөдөлгүүртэй автомашин, утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2003 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
Дуу шуугиан				
Дуу шуугиан, чичиргээ	Уурхайн талбай, тоног төхөөрөмжийн орчим, ажлын байранд 3 цэгт	Жилд 1 удаа, намар	200.0	MNS4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 5002:2000 Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
	Авто тээврийн зам дагуу	Жилд 1 удаа, намар		MNS4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Хөрсөн бүрхэвч				
Хөрсний нефть бүтээгдэхүүний бохирдол	Уурхайн гол зам, тосгон орчим 2 цэгт	Жилд 1 удаа	100.0	MNS 3473:1983 Газар. Газрын эдэлбэр. Газар ашиглалт. MNS 3297:1991 Хот суурин газрын хөрсний ариун Ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм хэмжээ
Ургамлан нөмрөг				
Ургамлан нөмрөгийн маршрутын судалгааны бичиглэлд заасан үзүүлэлтүүд, ургамлуудын мониторинг хийх	Төслийн талбайд	Жил бүрийн 9-р сард 2 удаа (Ургамлын цэцэглэлт ба үр жимс боловсрох үед)	-	ШҮА-ын ботантикийн хүрээлэн, МУИС-ийн ургамал судлалын тэнхимээс гаргасан хээрийн судалгааны арга, аргачлал
Амьтны аймаг				
Амьтны мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ	Төсөл хэрэгжих орчинд	Төсөл хэрэгжих хугацаанд	-	-
Төслийг хэрэгжүүлэх эхний жилийн зардлын урьдчилсан дүн			400.0	

4.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт 16. Олон нийтийн оролцоог хангах төлөвлөгөөний зардал

№	Ажлын нэр	Хэнд	Хариуцах эзэн	Хугацаа	Зардал
2	Нийт хийгдсэн ажлын хэмжээ, хийгдсэн ажлуудын тайлагнал	Төсөл хэрэгжих талбай орчмын нутгийн иргэд, холбогдох хүмүүс	Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн	Х сард	Дотоод зардал